



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 105

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрхлэгчийн 2017 оны 05 дугаар сарын 15,22-ны өдрүүдийн №30, 32 тоот тушаалаар сахилгын шийтгэлтэй харуул хамгаалалтын ажилтан Ж.Ганхүү, Б.Баянмөнх нарт 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр төрийн албан хаагчдад олгосон нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас 540,0 мянган төгрөг олгожээ.

Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны “Урамшуулал олгох тухай” 52 дугаар тэмдэглэлийг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан”... төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

D:\amaraa\2018\13-r tsetserleg\Akt ч.docx


2518091

1. Хууль, журам зөрчиж олгосон 540.000 /таван зуун дөчин мянган/ төгрөгийг Ж.Ганхүү, Г.Баянмөнх нараар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 05 дүгээр сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Төсвийн захирагч Ц.Оюунчимэг, нягтлан бодогч Ц.Одонгэрэл нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:
АУДИТОР *Ц. Амаржаргал* П.АМАРЖАРГАЛ



ЗӨВШӨӨРСӨН:
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ *Ц. Оюунчимэг* Ц.ОЮУНЧИМЭГ
НЯГТЛАН БОДОГЧ *Ц. Одонгэрэл* Ц.ОДОНГЭРЭЛ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 89

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд: Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад

1. 2017 оны 6 дугаар сарын 19-ны нягтлан бодогч Н.Уламбаяр нь шийдвэргүйгээр 3 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 284949 төгрөгийн бодож авсан.
2. 2017 оны 5,6,7,8,9,10-р саруудад Н.Уламбаяр нэртэй буюу 3-44-1 тоот хаягтай нэхэмжлэлээр 119,5 мянган төгрөгний цахилгааны төлбөрийг төсвөөс төлсөн.
3. Нягтлан бодогч Н.Уламбаяр нь 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдөр цалингийн урьдчилгаа 500,0 мянган төгрөг авч 400,0 мянган төгрөг эргэн төлөөгүй байна.
4. Бараа материалын тайланд орлогод авсан хүнсний материалыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын анхан шатны баримт зарлагын падаантай тулган шалгахад Софтвишин ХХК-д 390,8 мянган, Шижир титэм ХХК-д 79,8 мянган, Эрдэнэт адуун сүрэг ХХК-д 90,0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй нийт 560600 төгрөг шилжүүлж, хүнсний материал орлого авсан.
5. Аймгийн засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн дугаар А/871 тоот захирамжийг зөрчин 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр эрхлэгч Ц.Чимэгсайханд төрийн албан хаагчид олгох нэг удаагийн 300,0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", УИХ-ын 2017.11.09-ний өдрийн 67 тоот тогтоолоор батлагдсан 1 дэх "2017 оны төсвийн жилд төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуороос бусад төрийн албан хаагчдад 300,000 төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулал олгох" зэрэг заалтуудыг зөрчсөн байна.

2518059

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь ““Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон”, 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль , журам зөрчин олгосон 270000 /хоёр зуун далан мянган/ төгрөгийг Ц.Чимэгсайханаар, 284949 /хоёр зуун наян дөрвөн мянга есөн зуун дөчин есөн / төгрөгийг Н.Уламбаяраар
2. 2017 оны 6,7-р сард хоёр ажилтаны цалинг илүү мэдээлж, байгууллагас төлсөн НДШ-ийн 81259 /наян нэгэн мянга хоёр зуун тавин есөн/ төгрөгийг Н.Уламбаяр, Баянбаатар нараар
3. Н.Уламбаяр нэртэй буюу 3-44-1 тоот хаягтай нэхэмжлэлтэй гэрэл цахилгааны төлбөр болох 119500 /нэг зуун арван есөн мянга таван зуун/ төгрөгийг Н.Уламбаяраар
4. Цалингийн урьдчилгааг эргэн төлөөгүй 400000 /дөрвөн зуун мянган / төгрөгийг Н.Уламбаяраар
5. Анхан шатны баримтгүй хүнсий материал орлого авч мөнгийг нь шилжүүлсэн 560600 /таван зуун жаран мянга зургаан зуу / төгрөгийг дээрхи аж ахуйн нэгжүүдээр тус тус төлүүлж , Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.
6. Төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2018.05.20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн төсвийн захирагч Ц.Чимэгсайхан, нягтлан бодогч Н.Уламбаяр нарт хариуцуулав.

ТОГТООСОН¹:
ГЭРЭЭТ АУДИТОР
П.АМАРЖАРГАЛ
6417143544
БНДА0007 9007423

АКТ
ЗӨВШӨӨРСӨН:
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
НЯГТЛАН БОДОГЧ
Ц.ЧИМЭГСАЙХАН
Н.УЛАМБАЯР

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 90

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд: Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад

1. 2017 оны 12 дугаар сарын 24-ны өдөр ээлжийн амралтын мөнгө олгоходоо 2 ажилтанаас НДШ-ийн 140746, ХХОАТ-ын 126671 төгрөгийг суутгаагүй атлаа Нийгмийн даатгалын хэлтэст мэдээлсэн.

2. 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр 15-н ажилтанд 2017 оны 11 дүгээр сарын 27-ны №6/30 тоот даргын тушаалаар илүү цагын мөнгө олгоходоо НДШ-ийн 168910 төгрөг, ХХОАТ-ын 141979 төгрөгийг суутгаагүй олгосон.

3. 2017 онд ХХОАТ-т ажиллагсадын цалингаас 6680880 төгрөг суутгасан боловч Татварын хэлтэст 6600634 төгрөг шилжүүлэн 80246 төгрөг дутуу шилжүүлж өглөгөөр тусгаагүй.

4. Түүх угсаатны зүйн музейн даргын 2017 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн №6/16 тоот, 9 дүгээр сарын 20-ны өдрийн №6/23,24,25 тоот тушаалуудаар сахилгын шийтгэлтэй Д.Насантогтох, А.Гантулга, С.Азжаргал, Б.Намсрай нарт Төрийн албан хаагчийн нэг удаагийн урамшуулал олгосон.

Дээрх нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө", Татварын ерөнхий хуулийн 18.1.6 "Бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", УИХ-ын

2518062

2017.11.09-ний өдрийн 67 тоот тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны “Урамшуулал олгох тухай” 52 дугаар тэмдэглэл зэрэг заалтуудыг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь “Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон”, 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хавсралтад заасан ажилтнуудаар илүү цагийн хөлс болон ээлжийн амралтын мөнгөнөөс суутгаагүй нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын 578306 /таван зуун далан найман мянга гурван зуун зургаан / төгрөгийг

2. Хууль, журам зөрчин олгосон 1080000 / нэг сая наян мянган / төгрөгийг Д.Насантогтох, А.Гантулга, С.Азжаргал, Б.Намсрай нараар.

3. 2017 онд хувь хүний орлогын албан татварт ажилчдын цалингаас суутгасан боловч Татварын хэлтэст шилжүүлээгүй санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байсан 80246 төгрөгийг байгууллагын төсвөөс тус тус төлүүлж, Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

4. Төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2018.05.05-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн төсвийн захирагч А.Мандах, нягтлан бодогч Б.Намсрай нарт хариуцуулав.



1.Акт, албан шаардлагын биелэлт хангаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас таавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.